

**Баянтал сумын Засаг даргын 2023 оны Санхүүгийн тайлангийн аудитаар  
өгсөн зөвлөмж, албан шаардлын дагуу дотоод хяналт төлөвлөгөөний дагуу  
хийсэн ажлын тайлан**

**НЭГ. ДОТООД ХЯНАЛТЫН ЗОРИЛГО, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ**

**1.1. Дотоод хяналтын зорилт**

Төрийн хяналт шалгалтын тухай хуулт, Орон нутгийн өмчийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Татварын ерөнхий хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, бусад холбогдох хууль, тогтоомж, эрхзүйн актуудыг Баянтал сумын Засаг даргын дэргэдэх төсвийн байгууллагуудын хэрэгжүүлж буй байдалд дотоод хяналтыг хэрэгжүүлж, гарч болзошгүй эрсдлийг үнэлэх, үйл ажиллагааг сайжруулах талаар зөвлөмж өгч, дотоод хяналтын дүнг удирдлагад танилцуулахад оршино.

**1.2. Хамарсан хүрээ**

Сумын Баянтал сумын Засаг даргын дэргэдэх төсвийн байгууллагуудын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалт хийх төлөвлөгөө батлуулан, Дотоод хяналт шалгалт хариуцсан мэргэжилтэний баталсан удирдамжид заасны дагуу 20224 оны шилэн дасны хэрэгжилт, ебаримт, өмч хөрөнгийн хадгалалт хамгаалалттай холбоотой холбогдох анхан шатны баримтыг холбогдох эрхийн актуудтай тулган шалгаж дотоод хяналт хийсэн.

**1.3. Арга зүй**

Баянтал сумын Засаг даргын дэргэдэх төсвийн байгууллагуудад хийх төлөвлөгөөт боловсруулан батлуулж, Шилэн дасны хэрэгжилт, уахим баримт, өмч хөрөнгийн хадгалалт хамгаалалтад дотоод хяналтыг хэрэгжүүлж ажиллахдаа тухайн байгууллагад мөрдөгдөж байгаа хөдөлмөрийн аюулгүй ажиллагаатай холбоотой өгсөн зааварчилгаа, дотоод журмын хэрэгжилтэд хяналт хийж, мөрдөгдөн ажилладаг журмуудын хүрээнд хянан ил тод байдлаа хэрхэн хангаж ажилласан эсэхэд, анхан шатны баримт дотоод хяналт шалгалт хийгдэнэ.

**1.4 Ерөнхий мэдээлэл, дотоод хяналт явуулсан талаар**

**1.4.1** Сумын Засаг даргын дэргэдэх ЕБС, Соёлын төв, СӨБ, ЭМТ-ын шилэн дансанд оруулсан мэдээлэл, цаг хугацаандаа үнэн зөв оруулж байгаа эсэх, үндсэн хөрөнгийн хадгалалт хамгаалалт, бодлогын удирдамжийн хэрэгжилт, хөтөлбөр төслийн биелэлт зэргийг Засаг даргын дэргэдэх тасаг, алба, албан байгууллага, аж ахуйн нэгжид хэрхэн хэрэгжиж байгааг хангах, шалгах, зохицуулах, чиглэл өгөх, мэдээлэл авах зэрэг эрхтэйгээс гадна дээр байгууллагуудаар дамжуулан мэдээллийг цуглуулж хяналт шинжилгээ хийх дүгнэлт гаргах үүрэгтэй үйл ажиллагаагаа явуулж байна.

**1.4.2** Сумын засаг даргын дэргэдэх төсвийн байгууллагуудыг дотоод хяналтыг Төсвийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Төрийн өмч болон Төрийн өмчийн тухай хууль, ЗГ-ын 2015 оны 06 дугаар

сарын 269 дүгээр тогтоолын дагуу хийж дараах үйл ажиллагааг холбогдох журмын дагуу явагдаж байгаа эсэхийг хянан үзлээ. Үүнд:

1. Шилэн дансны хуулийн хэрэгжилт, ебаримт хэрхэн шивж, ил тод болгож байгаа эсэх
2. Өмчийн бүртгэл тооцоо ашиглалт, хамгаалалт, санхүү бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт тавих
3. Дотоод хяналт шалгалт хийсэн талаар мэдээллээ бүртгэл бий болгох, цахим сайтад байршуулах  
Гэсэн дотоод хяналт шалгалтын төлөвлөгөөний дагуу хяналт шалгалтыг хийнэ.

#### **1. Шилэн данс болон ебаримт**

Тус төсвийн байгууллагад нь шилэн дансанд мэдээллээ оруулж байгаа боловч шилэн дансны ил тод байдлыг хангаж ажиллаагүй байна. Тухайлбал: ЭМТ, Соёлын төв, ЕБС, СӨБ шилэн дансанд 7 хонгийн дотор оруулах санхүүжилтийн мэдээллийг тухай бүр оруулаагүй хугацаа хоцроож оруулсан байна. Мөн Худалдан авах ажиллагаатай холбоотой гэрээнүүдийг мэдээллүүдийг шилэн дансанд оруулаагүй байна. Ебаримтын хувьд бүх байгууллагууд цахимаар гүйлгээ хийж байгаа учраас илүү, дутуу ебаримт шиевэгдээгүй байна.

#### **2. Өмчийн бүртгэл тооцоо, ашиглалт хамгаалалт, санхүү бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийсэн эсэх**

Тус байгууллагууд өмч хөрөнгийн хадгалалт хамгаалалтад хяналт шалгалт хийхэд шинээр авсан үндсэн хөрөнгүүдээ бүртгэлжүүлээгүй, баар код наагаагүй, хугацаа нь дууссан хөрөнгүүдээ актлаж устгах, эсвэл данх үнэлгээ хийлгэх талаар анхаарч ажиллах нийтлэг зөрчил дутагдлууд илэрч байлаа.

#### **3. Дотоод хяналт шалгалтын хийсэн талаар мэдээллийн бүртгэл бий болгох цахим сайтад дотоод хяналт шалгалтын тайланг байршуулсан эсэх**

Ихэнх байгууллагууд дотоод хяналт шалгалтын ажилтантай боловч яг ямар ажил хийх талаар нарийн төлөвлөгөө гаргаж батлуулаагүй байна. Зөвхөн СӨБ, ЕБС –ууд зөвхөн дотоод сургалтын төлөвлөгөө болон хүүхдийн өдөрлөгийн хоолны төлөвлөгөөнд дээр хяналт шалгалт хийж санхүүтэй холбоотой баримт материал дээр хяналт шалгалт хийгдээгүй байна. Хяналт шалгалт хийсэн ажлын тайлангаа цахим сайтад байршуулаагүй.

### **ХОЁР. ДОТООД ХЯНАЛТААР ИЛЭРСЭН ЗӨРЧЛИЙН ТАЛААР**

- ЕБС, ЭМТ, Соёлын төв, ЭМТ нар шилэн дансны ил тод байдлыг хангаж ажиллаагүй, мэдээ тайланг хугацаа хоруулан оруулсан зөрчил илэрлээ.
- Хугацаа дууссан хөрөнгүүдийг акт устгах ажлыг зохион байгуулж ажиллаагүй, үндсэн хөрөнгүүдээр баар код наагаагүй зөрчил дутагдал нийтлэг илэрлээ.

- Дотоод хяналт ажилтан хяналт шалгалтын төлөвлөгөөгөө гаргахдаа санхүүтэй холбоотой өмч хөрөнгийн хадгалалт хамгаалалт хянал тавьж, ажлын төлөвлөгөөндөө оруулж өгөөгүй, цахим мэдээллийн санд байршуулж ажиллаагүй зөрчил дутагдал илэрлээ.

**ГУРАВ. ЗӨВЛӨМЖ**

**Байгууллагын дарга нарт**

- Шилэн дансанд худалдан авах ажиллагаатай холбоотой мэдээллүүдийг тухай бүр нь оруулж байх
- Өмч хөрөнгийн хадгалалт хамгаалалтыг сайжруулан, үндсэн хөрөнгийг баар коджуулах ажлыг зохион байгуулан ажиллах
- Дотоод хяналтын ажилтан Дотоод хяналтын төлөвлөгөө нарийн гаргаж батлуулах
- Зөвлөмжийг 2024 оны 10 дугаар сарын 15-ны доторирүүлэх
- Шалгалтын тайланг холбогдох байгууллагуудад хүргүүлэх

**ТАВ. ТАЙЛАНГИЙН БАТАЛГААЖУУЛАЛТ**

Дотоод хяналт шалгалт тайланг хянасан:

Баянтал сумын Засаг дарга

Дотоод хяналт шалгалт хийсэн

Баянтал сумын ЗДТГ-ын Дотоод хяналт шалгалт хариуцсан мэргэжилтэн



/Б.Ганбаяр/

/Л.Отгонпүрэв/